



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/120/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2021
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа Уул Аудит ХХК

Захирал: Ч.Мөнхтуяа

Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын ТАЙЛАН	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.3 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
НХМ	Нэг хэвийн маягт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/142
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Ц.ТУНГАЛАГТАМИР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022 он/ALBAN BICHIG

19020458

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,602,553.26	78,446,856.38
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	4,115,026.52
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	4,115,026.52
31210	Төгрөг	0.00	4,115,026.52
31211	Төрийн сангийн харилцах	0.00	4,115,026.52
33	АВЛАГА	0.00	29,136,900.00
33500	Бусад авлага	0.00	29,136,900.00
33510	Байгууллагаас авах авлага	0.00	29,136,900.00
35	БАРАА МАТЕРИАЛ	31,602,553.26	45,194,929.86
35100	Түүхий эд материал	18,606,101.89	30,662,409.49
35110	Тусгай зориулалттай материал	6,105,413.98	6,105,413.98
35130	Эм боох материал	12,500,687.91	24,556,995.51
35400	Хангамжийн материал	12,996,451.37	14,532,520.37
35410	Бичиг хэргийн материал	1,075,612.37	1,075,612.37
35420	Аж ахуйн материал	10,597,986.00	10,837,386.00
35430	Сэлбэг хэрэгсэл	180,000.00	180,000.00
35460	Хүнсний материал	758,853.00	2,055,522.00
35470	Бусад хангамжийн материал	384,000.00	384,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	268,730,159.11	294,058,105.81
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	268,730,159.11	294,058,105.81
39200	Биет хөрөнгө	266,104,159.11	291,432,105.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	180,112,714.11	230,520,684.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	-6,876,431.78	-14,558,001.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	102,120,200.00	34,945,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-63,270,200.00	-13,945,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	118,455,417.26	131,721,374.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	-66,049,811.37	-79,553,549.39
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,855,351.32	32,555,351.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	-30,243,080.43	-30,730,163.81
39214	Бусад үндсэн хөрөнгө	0.00	476,410.00
39300	Биет бус хөрөнгө	2,626,000.00	2,626,000.00
39301	Програм хангамж	185,000.00	185,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-185,000.00	-185,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,626,000.00	2,626,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	300,332,712.37	372,504,962.19
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	418,254.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	418,254.00
41300	Өглөг	0.00	418,254.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	418,254.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	300,332,712.37	372,086,708.19
51	Засгийн газрын хувь оролцоо	300,332,712.37	372,086,708.19
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	140,154,447.30	140,154,447.30
51200	Хуримтлагдсан үр дүн	799,355.07	73,865,133.27
51210	Өмнөх үеийн үр дүн	-17,058,549.91	2,111,137.45
51220	Тайлант үеийн үр дүн	17,857,904.98	71,753,995.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	159,378,910.00	158,067,127.62
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	300,332,712.37	372,504,962.19

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	365,706,472.62	664,879,506.87
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	55,005,948.62	256,680,841.87
120	Нийтлэг татварын бус орлого	55,005,948.62	256,680,841.87
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	41,017,960.00	64,850,337.56
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – БМ	13,987,988.62	191,830,504.31
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	310,700,524.00	408,198,665.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	277,301,000.00	321,385,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	277,301,000.00	321,385,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,656,224.00	51,261,655.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,656,224.00	51,261,655.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,743,300.00	27,458,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,743,300.00	27,458,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	8,093,310.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0.00	8,093,310.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	347,848,567.64	581,569,789.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	347,848,567.64	581,401,340.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	346,465,084.61	579,854,581.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	219,124,421.12	247,312,747.42
210101	Үндсэн цалин	141,922,200.00	162,922,716.61
210102	Нэмэгдэл	64,254,200.00	53,183,766.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,384,000.00	4,562,366.50
210104	Урамшуулал	11,564,021.12	26,643,898.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,250,902.05	34,231,103.06
210201	Тэтгэврийн даатгал	22,423,302.05	24,088,499.13
210202	Тэтгэмжийн даатгал	2,206,900.00	2,535,699.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,765,500.00	2,028,499.52
210204	Ажилгүйдлийн даатгал	441,400.00	507,106.64
210205	Эрүүл мэндийн даатгал	4,413,800.00	5,071,298.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,287,007.00	25,775,097.00
210301	Гэрэл, цахилгаан	2,544,702.00	2,435,097.00
210302	Түлш, халаалт	21,607,305.00	23,040,000.00
210303	Цэвэр, бохир ус	135,000.00	300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,790,401.00	16,316,410.00
210401	Бичиг хэрэг	2,147,200.00	967,300.00
210402	Тээвэр, шатахуун	7,454,560.00	13,236,860.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	805,850.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	1,306,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,330,550.00	0.00
210408	Бараа материал акталсны зардал	4,738,091.00	0.00
2105	Нормативт зардал	18,768,601.49	193,067,159.71
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,640,037.49	189,585,928.71
210502	Хоол, хүнс	4,128,564.00	3,481,231.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	80,000.00	5,529,925.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	80,000.00	1,350,425.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	3,099,500.00

Төв аймгийн Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	0.00	1,080,000.00
2107	Томилолт, зочны зардал	182,000.00	12,000.00
210702	Дотоод албан томилолт	182,000.00	12,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,165,200.00	0.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	902,200.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	263,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,816,551.95	57,610,138.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,054,790.00	28,887,748.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,761,761.95	28,722,390.86
211	ХҮҮ	0.00	5,156.00
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	0.00	5,156.00
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	0.00	5,156.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,383,483.03	1,541,603.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,008,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,470.00	533,603.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	533,603.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,470.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,382,013.03	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,382,013.03	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	168,449.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	168,449.00
223001	Хаагдсан данс	0.00	168,449.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	17,857,904.98	83,309,717.82
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	11,555,722.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	10,800,000.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0.00	755,722.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	17,857,904.98	71,753,995.82

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	140,154,447.30	159,378,910.00	-17,058,549.91	282,474,807.39
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	140,154,447.30	159,378,910.00	-17,058,549.91	282,474,807.39
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	17,857,904.98	17,857,904.98
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	140,154,447.30	159,378,910.00	799,355.07	300,332,712.37
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	140,154,447.30	159,378,910.00	799,355.07	300,332,712.37
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	1,311,782.38	1,311,782.38
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-1,311,782.38	0.00	-1,311,782.38
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	71,753,995.82	71,753,995.82
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	140,154,447.30	158,067,127.62	73,865,133.27	372,086,708.19

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	310,700,524.00	379,061,765.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	310,700,524.00	379,061,765.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	277,301,000.00	321,385,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	277,301,000.00	321,385,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,656,224.00	22,124,755.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,656,224.00	22,124,755.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,743,300.00	27,458,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,743,300.00	27,458,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	8,093,310.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0.00	8,093,310.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	309,314,524.00	374,778,289.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	309,314,524.00	374,778,289.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	307,931,040.97	373,231,530.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	219,124,421.12	247,312,747.42
210101	Үндсэн цалин	141,922,200.00	162,984,047.42
210102	Нэмэгдэл	64,254,200.00	54,155,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,384,000.00	4,788,000.00
210104	Урамшуулал	11,564,021.12	25,385,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,250,902.05	34,231,103.06
210201	Тэтгэврийн даатгал	22,423,302.05	24,088,499.13
210202	Тэтгэмжийн даатгал	2,206,900.00	2,535,699.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,765,500.00	2,028,499.52
210204	Ажилгүйдлийн даатгал	441,400.00	507,106.64
210205	Эрүүл мэндийн даатгал	4,413,800.00	5,071,298.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,412,007.00	25,775,097.00
210301	Гэрэл, цахилгаан	2,529,702.00	2,435,097.00
210302	Түлш, халаалт	21,607,305.00	23,040,000.00
210303	Цэвэр, бохир ус	275,000.00	300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,280,790.00	16,819,410.00
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	902,300.00
210402	Тээвэр, шатахуун	12,600,390.00	13,236,860.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	899,600.00	880,850.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,780,800.00	1,799,400.00
2105	Нормативт зардал	7,579,920.80	16,489,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,893,010.80	11,889,200.00
210502	Хоол, хүнс	2,686,910.00	4,599,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,495,850.00	5,848,925.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	294,000.00	1,599,425.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,099,050.00	3,099,500.00
210604	Урсгал засвар	1,102,800.00	1,150,000.00
2107	Томилолт, зочны зардал	182,000.00	12,000.00
210702	Дотоод албан томилолт	182,000.00	12,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,185,150.00	0.00

Төв аймгийн Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,007,150.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	178,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	420,000.00	26,743,148.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	420,000.00	26,743,148.00
211	ХҮҮ	0.00	5,156.00
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	0.00	5,156.00
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	0.00	5,156.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,383,483.03	1,541,603.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,008,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,470.00	533,603.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	533,603.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,470.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,382,013.03	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,382,013.03	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,386,000.00	4,283,475.52
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,386,000.00	168,449.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,386,000.00	168,449.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,386,000.00	168,449.00
223001	Бусад хөрөнгө	0.00	168,449.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,386,000.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,386,000.00	-168,449.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	4,115,026.52
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	4,115,026.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	365,488,300.00	352,288,380.48	13,199,919.52	96.4
УРСГАЛ ЗАРДАЛ	365,488,300.00	352,288,380.48	13,199,919.52	96.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	365,488,300.00	352,288,380.48	13,199,919.52	96.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	253,564,200.00	247,312,747.42	6,251,452.58	97.5
Үндсэн цалин	169,235,500.00	162,984,047.42	6,251,452.58	96.3
Нэмэгдэл	54,155,400.00	54,155,400.00	0.00	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	4,788,000.00	4,788,000.00	0.00	100.0
Урамшуулал	25,385,300.00	25,385,300.00	0.00	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,231,200.00	34,231,103.06	96.94	100.0
Тэтгэврийн даатгал	24,088,500.00	24,088,499.13	0.87	100.0
Тэтгэмжийн даатгал	2,535,700.00	2,535,699.15	0.85	100.0
ҮОМШӨ-ний даатгал	2,028,500.00	2,028,499.52	0.48	100.0
Ажилгүйдлийн даатгал	507,200.00	507,106.64	93.36	100.0
Эрүүл мэндийн даатгал	5,071,300.00	5,071,298.62	1.38	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,308,700.00	25,775,097.00	533,603.00	98.0
Гэрэл, цахилгаан	2,961,500.00	2,435,097.00	526,403.00	82.2
Түлш, халаалт	23,047,200.00	23,040,000.00	7,200.00	100.0
Цэвэр, бохир ус	300,000.00	300,000.00	0.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	19,645,000.00	16,819,410.00	2,825,590.00	85.6
Бичиг хэрэг	1,000,000.00	902,300.00	97,700.00	90.2
Тээвэр, шатахуун	15,945,000.00	13,236,860.00	2,708,140.00	83.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	880,850.00	19,150.00	97.9
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,800,000.00	1,799,400.00	600.00	100.0
Нормативт зардал	18,889,200.00	16,489,100.00	2,400,100.00	87.3
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,889,200.00	11,889,200.00	0.00	100.0
Хоол, хүнс	7,000,000.00	4,599,900.00	2,400,100.00	65.7
Эд хогшил, урсгал засварын зардал	5,850,000.00	5,848,925.00	1,075.00	100.0
Багаж, техник, хэрэгсэл	1,600,000.00	1,599,425.00	575.00	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,100,000.00	3,099,500.00	500.00	100.0
Урсгал засвар	1,150,000.00	1,150,000.00	0.00	100.0
Томилолт, зочны зардал	1,000,000.00	12,000.00	988,000.00	1.2
Дотоод албан томилолт	1,000,000.00	12,000.00	988,000.00	1.2
Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	5,799,998.00	200,002.00	96.7
Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	5,799,998.00	200,002.00	96.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	365,488,300.00	356,403,407.00	9,084,893.00	97.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	321,385,000.00	321,385,000.00	0.00	108.5
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	321,385,000.00	321,385,000.00	0.00	100.0
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	27,458,700.00	27,458,700.00	533,603.00	-

Төв аймгийн Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Орон нутгийн төсвөөс	27,458,700.00	26,925,097.00	533,603.00	-
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	16,644,600.00	8,093,310.00	8,551,290.00	48.6
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	16,644,600.00	8,093,310.00	8,551,290.00	48.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0	0.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	4,115,026.52	-4,115,026.52	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,124,755.00
УРСГАЛ ЗАРДАЛ	22,124,805.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,116,805.00
Бараа үйлчилгээний бусад зардал	21,116,805.00
Бараа үйлчилгээний бусад зардал	21,116,805.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,008,000.00
Бусад урсгал шилжүүлэг	1,008,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,008,000.00
Нэмэлтийн орлого	22,124,755.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,124,755.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийн ашиглах жилийг сунгах, тооллогын бүртгэл, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-аас 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Уваа уул Аудит ХХК-ийн аудитор Б.Буяндэлгэр, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанар хяналтыг захирал Ч.Мөнхтуяа хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Уваа уул аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16.4 дэх заалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаал "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 347,848.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,478.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн **гүйцэтгэлийн** материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,435.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд Орон нутгийн төсвөөс 27,458.7 мянга, хандив тусламжийн эх үүсвэрээс 8,093.3 мянган төгрөгийн санхүүжилтийг 100.0 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 22,124.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 22,124.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд хандиваар 64,850.3 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, 67,175.2 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Бараа материалын дансанд хандиваар 200,838.6 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 36,676.5 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 223,922.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 29,136.9 мянган төгрөгийн авлагатай, 418.3 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнагдсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 4,115.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 45,194.9 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 294,058.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	4,115.0	4,115.0
Авлага	0.0	29,136.9	29,136.9
Бараа материал	31,602.1	45,194.9	13,592.4
Үндсэн хөрөнгө	268,730.2	294,058.1	25,327.9
Нийт хөрөнгө	300,332.7	372,503.0	72,170.3
Өглөг	0.0	418.3	418.3
ЗГ-н оруулсан капитал	140,154.4	140,154.4	-
Хуримтлагдсан үр дүн	799.4	73,865.1	73,065.7
Нийт ер төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	300,332.7	372,503.0	72,170.3

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 4,115.0 мянган төгрөг байгаа нь Сангийн яамнаас ЭМЯ-ны харьяа байгууллагуудын улсын төсөв, нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг татан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.
- Авлага дансны үлдэгдэл 29,136.9 мянган төгрөгөөр өссөн нь ЭМДС-аас авах нэмэлт санхүүжилтийг тусгаснаас шалтгаалсан байна.
- Бараа материалын данс өмнөх оноос 13,592.4 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан эм боох материалын дансанд Эрүүл мэндийн газраас 104,542.7 мянган төгрөгийн вакцин авснаас голлон шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны өөрчлөлт: Төв аймгийн Эрүүл мэндийн газраас 4,789.3 мянган, аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс хандив тусламжаар 60,061.0 мянган төгрөгийн хөрөнгө тус тус орлогод авснаас шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус Эрүүл мэндийн төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 277,301.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 27,458.7 мянган төгрөг, ЭМДСангаас 16,746.1 үүнээс урсгал зардалд 321,505.8 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 43,982.5 мянган төгрөгөөр нэмж 365,488.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 321,385.0 мянга, орон нутгийн төсвөөс 26,925.0 мянган төгрөг, ЭМДСангаас 8,093.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 352,288.3 мянган төгрөгийг зарцуулж, 4,115.0 мянган төгрөгийг үлдэгдэлтэй гарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 352,288.3 мянган төгрөг буюу 96.3 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 22,124.8 мянган төгрөг төвлөрч, бараа үйлчилгээний бусад зардалд 22,124.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд хандиваар 64,850.3 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, 67,175.2 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Хэвтэн эмчлүүлэгчийн тусламж үйлчилгээ, амбулаторийн тусламж үйлчилгээ болон оношилгоо шинжилгээний тусламж үйлчилгээ буурч зөвхөн ковидын тусламж үйлчилгээ үзүүлснээс үүдэн ЭМДС-аас авах санхүүжилт 8,551.3 мянган төгрөгөөр буурсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 3 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгахад шалгагдагч байгууллага нь Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангаа бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төсвийн гүйцэтгэлийн тайлангаа иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, хөрөнгө худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 54.5, Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.4 дэх заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байгааг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3 алдаа зөрчилд 3 зөвлөмж өглөө.

4.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 79,297.6 мянган төгрөгийн хөрөнгө байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ТӨБЗГ-н тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоох, зөрчлийг давтан гаргахгүй байх

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн тооллогын баримтад эд хариуцагчийг карт, тооцоо бодсон баримт, тооллогын комиссын илтгэх хуудас, өмч хамгаалах зөвлөлийн тэмдэглэл, байгууллагын удирдлагад танилцуулсан тэмдэглэл, тооллогын баталгаа хийгдээгүй зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д. “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй...”, 72 дугаар зүйлийн 72.4-д “Тооллогын комисс дараах үүрэгтэй...” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тооллогын ажлыг чанартай явуулж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Харилцахын үлдэгдэл, авлага, өглөгийн тооцоог жилийн эцсээр нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус нийцэхгүй, санхүүгийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллага, иргэдтэй тооцоо нийлж авлага, өр төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төв аймгийн Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төв	3								3	-
	ДҮН	3								3	-